

Бизнесийн төлөвийн түүвэр судалгаа (2025 оны I улирал)

Хураангуй:

“Бизнесийн төлөвийн түүвэр судалгаа”-ны мэдээллийг 2025 оны 4 дүгээр сард цуглуулж, 387 аж ахуйн нэгжийн хариултад үндэслэн судалгааны үр дүнг нэгтгэлээ.

- Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн дийлэнх нь хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК) хэлбэртэй, хүнсний болон хүнсний бус боловсруулах үйлдвэрлэл, барилга, дотоод худалдааны салбарт үйл ажиллагаа эрхэлдэг, 10-аас дээш жил ажилласан туршлагатай, 200 хүртэл ажилчидтай, 2.5 тэрбум төгрөгөөс дээш жилийн борлуулалтын орлоготой байна.

- **Инфляцын хүлээлт:**


Аргачлал	2025 оны II улиралд	2026 оны I улиралд
Мэдрэмжид суурилсан	12.2%	14.0%
Чанарын хариултаас тооцсон	11.4%	12.4%
Тоон хариултаас тооцсон	9.6%	10.4%

- Ирэх 3 сард хүнс (гурил, будаа, талх)-ны үйлдвэрлэл, боловсролын үйлчилгээ эрхэлдэг ААН-үүдийн хувьд бараа, үйлчилгээний үнэ нэмэгдэх хандлага түлхүү байгаа бол ирэх 12 сард боловсрол болон тээврийн үйлчилгээ, бусад төрлийн хүнсний бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн өсөлт одоогийнхоос эрчимжих хүлээлт давамгайлж байна.
- **Эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт:** өмнөх улирлаас 9.0 нэгжээр буурч, 89.7 нэгжид хүрсэн нь эдийн засгийн нөхцөл муудах хүлээлттэй байгааг илтгэж байна. Ийнхүү муудахад дотоод худалдаа, үйлчилгээний салбарын борлуулалтын орлого, мөн барилгын салбарын хүлээлтүүд буурсан нь голлон нөлөөллөө.
- **Ажил эрхлэлтийн хүлээлт:** тайлант улиралд 108 нэгжид хүрч, тэлэлтийн мужид хадгалагдаж байгаа хэдий ч өмнөх улирлаас 13.3 нэгжээр буурсан нь ажиллагсдын өсөлт саарах дохиог илтгэж байна. Энэ өөрчлөлтөд аж үйлдвэр, үйлчилгээ, дотоод худалдааны салбарын хүлээлтүүд буурсан нь голлон нөлөөллөө.
- **Эдийн засгийн тодорхой бус байдал:** тайлант улиралд өмнөх улирлаас 9.1 нэгжээр өсөж, 141 нэгжид хүрлээ. Уг өсөлт нь бүх салбарт ажиглагдсан бөгөөд эдийн засгийн тодорхой бус байдал өргөн хүрээнд нэмэгдсэнийг илтгэж байна.


I. Аж ахуйн нэгжүүдийн инфляцын хүлээлт

Судалгаанд хамрагдсан ААН-үүдээс инфляц хэрхэн өөрчлөгдөх талаар асууж, чиглэлийн индексийг тооцоход ирэх 3 сар болон 12 сарын чиглэлийн индексийн утгууд өнгөрсөн улирлын түвшнээс өөрчлөлт багатай гарлаа. Ирэх 12 сарын үнийн хүлээлтийн чиглэлийн индексийн утгын хувьд “Үнийн өсөлт өснө” мужид шилжсэн бол ирэх 3 сарын үнийн хүлээлтийн чиглэлийн индексийн утга “Үнийн өсөлт одоогийн түвшинд хадгалагдах” мужид хэвээр үлдлээ (Зураг 1.1).

Зураг 1.1: Инфляцын хүлээлтийн индекс, ирэх 3 болон 12 сарын хугацаанд



Зураг 1.2: Инфляцын хүлээлтийн, ирэх 3 болон 12 сарын хугацаанд



Ирэх 3 сард буюу 2025 оны II улирлын инфляцын хүлээлт¹ чанарын хариултын² хувьд **11.4%** бол мэдрэмжид суурилсан хүлээлт **12.2%**-тай гарлаа. Энэ удаагийн судалгаагаар мэдрэмжид суурилсан инфляцын хүлээлтийн утга болон чанарын хариултаас тооцсон хүлээлтийн утга өмнөх улирлаас 1.9 болон 1.7 нэгж хувиар тус тус өссөн нь ААН-үүдийн хувьд ирэх 3 сард үнийн өсөлт цаашид нэмэгдэх хүлээлт өндөр байгааг илэрхийлж байна. Мөн тоон хариултаас тооцсон инфляцын хүлээлтийн утга өмнөх улирлаас 1.8 нэгж хувиар өсөж, **9.6%**-тай гарлаа (Зураг 1.2).

Ирэх 12 сард буюу 2026 оны I улирлын инфляцын хүлээлтийн утга чанарын хариултын хувьд **12.4%**, мэдрэмжид суурилсан хариултаар **14.0%**, тоон хариултаар **10.4%** байхаар хүлээгдэж байна. Чанарын хариултаас тооцсон хүлээлтийн утга өмнөх улирлаас 1.8 нэгж хувиар өссөн бол мэдрэмжид суурилсан хүлээлтийн утга өмнөх улирлаас 3.1 нэгж хувиар тус тус өссөн нь үнийн өсөлт цаашид нэмэгдэж болзошгүйг илтгэж байна. Харин тоон хариултаас тооцсон инфляцын хүлээлтийн утга 2.4 нэгж хувиар нэмэгдэж, 2025 оны I улирлын инфляцын утгатай ойролцоо түвшинд гарлаа (Зураг 1.2).


¹ Хүлээлтийн утгыг тооцохдоо ХҮИ-д тулгуурлаж байгаа тул үнийн ерөнхий хандлагыг харуулна. Энэхүү тооцсон хүлээлтийн утга нь инфляцын утгыг шууд илэрхийлэхгүй болно.

² Чанарын хариултыг Карлсон-Паркины аргачлалд тулгуурлан тоон үзүүлэлт рүү шилжүүлж тооцсон болно.


Судалгаанд оролцсон нийт аж ахуйн нэгжүүдийг борлуулалтын дийлэнх хувийг бүрдүүлдэг бараа, үйлчилгээний төрлийг үндэслэн ХҮИ-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээний бүлгийн бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг, худалдаалдаг болон үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгжүүдээр нь тус тус бүлэглэлээ. Уг бүлгээр инфляцын хүлээлтийн хариултыг харьцуулахад ирэх 3 сард дийлэнх аж ахуйн нэгжүүд (46%) үнийн өсөлт 12.0 хувиас их байх хүлээлттэй байна. Тухайлбал, боловсролын үйлчилгээ, гэр ахуйн бараа, хүнс (талх, гурил, будаа зэрэг төрлийн хүнсний бүтээгдэхүүн)-ний үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн үнийн өсөлт хамгийн өндөр хүлээлттэй байгаа бол орон сууц, ус, цахилгаан, гэр ахуйн барааны үйлдвэрлэл, худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд үнийн өсөлт харьцангуй бага байх буюу инфляц 10.0 хувиас бага байх хүлээлт давамгайлж байна (Зураг 1.3).

Ирэх 12 сард дийлэнх аж ахуйн нэгжүүд (36%) үнийн өсөлт 10.0 хувиас бага байх хүлээлттэй байгаа хэдий ч боловсролын болон тээврийн үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн хувьд үнийн өсөлт 12.0 хувиас их байх хүлээлт илүү давамгайлж байна. Эм эмнэлгийн үйлчилгээ, орон сууц, ус, цахилгаан, хувцас бөс барааны үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн дунд инфляц 10.0 хувиас бага байх хүлээлттэй байна (Зураг 1.4). Эдгээр бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл нь Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индексийн 53.4 хувийн жинг бүрдүүлдэг барааны бүлэг байна.

Зураг 1.3: ААН-ийн ирэх 3 сарын инфляцын хүлээлт, тоон хариулт, /бүтээгдэхүүн, үйлчилгээний бүлгээр/




Зураг 1.4: ААН-ийн ирэх 12 сарын инфляцын хүлээлт, тоон хариулт, /бүтээгдэхүүн, үйлчилгээний бүлгээр/



Тоон хариултын интервал тус бүрийн дундаж утгыг жигнэн, инфляцын хүлээлтийн утгыг тооцвол инфляц ирэх 3 сард **9.6%**, ирэх 12 сард **10.4%**-тай байх хүлээлттэй байна (Зураг 1.5).

Зураг 1.5: ААН-ийн ирэх хугацааны инфляцын хүлээлтийн тархалт, тоон хариулт




II. Бизнесийн үйл ажиллагааны төлөв

Эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт ESI³

Монгол Улсын эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт өмнөх улирлын утгаас 9.0 нэгж хувиар буурч, 2025 оны I улиралд 89.7 утгатай гарлаа. Мэдрэмжийн үзүүлэлт өнгөрсөн улирлын өөрчлөлтгүй төлөвөөс бага зэрэг муудаж эдийн засаг агших муж руу шилжлээ. Тус мэдрэмжийн үзүүлэлтийн бууралтад үйлчилгээний салбарын өнгөрсөн улирлын борлуулалтын орлого буурсан нь голлох нөлөөг үзүүллээ (Зураг 2.1). Тус үзүүлэлтийг ерөнхий салбаруудаар харвал зөвхөн хэрэглэгчдийн мэдрэмжийн индекс 100-с дээш утгатай (хэрэглэгч 101.7) буюу эдийн засгийн нөхцөл байдал сайжрах түвшинд хэвээр хадгалагдсан бол бусад салбарууд (барилга 98.1, аж үйлдвэр 90.7, үйлчилгээ 82.8, дотоод худалдаа 80.9) агшилтын мужид гарлаа. Энэхүү үзүүлэлтийг өмнөх улирлын үр дүнтэй харьцуулахад бүх салбарын үзүүлэлтүүдэд бага зэрэг буурсан (үйлчилгээ -22.1, дотоод худалдаа -11.4, барилга -9.2, хэрэглэгч -1.8, аж үйлдвэр -0.6) буюу эдийн засгийн төлөв байдал муудсан дүр зурагтай байна (Зураг 2.2).

³ Economic Sentiment Index

Зураг 2.1 Эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт



Зураг 2.2: Эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт, салбараар




Тэмдэглэл: Энэхүү үзүүлэлт нь эдийн засагт оролцогч талуудын (хэрэглэгч) өнгөрсөн 3 сарын сайжирч байгааг илтгэх бөгөөд тус нийлмэл шинэ захиалга, борлуулалт (санхүүгийн байдал, үзүүлэлтийг тооцохдоо Евро комиссын “European business cycle indicators” тайлангийн аргачлалыг сарын үйлдвэрлэл болон ажил эрхлэлт (санхүүгийн байдал, хэрэглээ, эдийн засгийн нөхцөл байдал) зэрэг үзүүлэлтүүдийн талаарх хүлээлтийн дунджаар тодорхойлогдох бөгөөд Евро комиссын “European business cycle indicators” тайлангийн аргачлалд тулгуурлан тооцлоо. Үзүүлэлт 100-с дээш гарах нь эдийн засгийн нөхцөл байдал сайжрах, 100-с бага бол эдийн засгийн нөхцөл байдал муудах төлөвийг илэрхийлнэ.

Ажил эрхлэлтийн хүлээлт (EEI)⁴


Тайлант улиралд 108 утгатай буюу 100-с дээш гарсан нь ажиллагсдын тоо ирэх улиралд нэмэгдэх хүлээлттэй байгаа хэдий ч өмнөх улирлаас 13.3 нэгж хувиар буурсан нь цаашид энэхүү өсөлт саарах дохиог илтгэж байна (Зураг 2.3). Энэхүү бууралтад аж үйлдвэр, үйлчилгээ болон дотоод худалдааны салбарын ажил эрхлэлтийн хүлээлт буурсан нь голлох нөлөөг үзүүллээ. Ажил эрхлэлтийн талаарх хүлээлтийн үзүүлэлтийн хувьд аж үйлдвэрийн салбарын хүлээлт буурч агших муж руу шилжсэн бол бусад салбарууд тэлэлтийн мужид хэвээр хадгалагдлаа (барилга 121.3, дотоод худалдаа 111.9, үйлчилгээ 110.6, аж үйлдвэр 95.2). Тус үзүүлэлтийг өмнөх улирлын утгатай харьцуулахад бүх салбарт ажил эрхлэлтийн хүлээлт (аж үйлдвэр -27.8, үйлчилгээ -11.5, дотоод худалдаа -7.0, барилга -1.4) буурсан үзүүлэлттэй гарлаа (Зураг 2.4).

⁴ Economic Employment Index

Зураг 2.3. Ажил эрхлэлтийн хүлээлтийн үзүүлэлт



Зураг 2.4. Ажил эрхлэлтийн хүлээлт, салбараар




Эдийн засгийн тодорхой бус байдал (EUI)⁵

Монгол Улсын эдийн засгийн тодорхой бус байдлын талаар аж ахуйн нэгж, иргэдээс асууж, хүлээлтийн утгыг тооцоход 2025 оны I улиралд өмнөх улирлаас 9.1 нэгж хувиар өсөж, 141 утгатай гарлаа. Тус үзүүлэлт нь 100-с дээш утгатай байгаа нь эдийн засагт тодорхой бус байдал өндөр хэвээр байгааг илтгэж байна (Зураг 2.5). Мөн дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдлын үзүүлэлт нэмэгдсэн байна. Тухайлбал, ОУВС-гаас эрхлэн гаргадаг “Дэлхийн эдийн засгийн төлөв” тайланд гадаад худалдааны тарифын хувь хэмжээ сүүлийн зуун жилд ажиглагдаагүй өндөр түвшинд хүрсэн нь тодорхой бус байдал нэмэгдэхэд голлох нөлөөг үзүүлсэн талаар онцолсон. Мөн геополитикийн нөхцөл байдал, гадаад худалдааны хамгаалах бодлогууд эдийн засгийн урт хугацааны өсөлт болон нийлүүлэлтийн гинжин хэлхээний уян хатан байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй байна.


Голлох салбаруудын хувьд авч үзвэл эдийн засгийн тодорхой бус байдлын үзүүлэлт хэрэглэгчдэд хамгийн өндөр, харин барилгын салбарт харьцангуй бага (хэрэглэгч 155.6, аж үйлдвэр 147.7, үйлчилгээ 127.4, дотоод худалдаа 122.4, барилга 121.3) гарлаа. Тус үзүүлэлтүүдийг өмнөх улирлын утгатай харьцуулахад хэрэглэгчдийн утгаас бусад үзүүлэлтүүд өссөн (аж үйлдвэр +16.7, дотоод худалдаа +15.6, барилга +11.9, үйлчилгээ +8.8, хэрэглэгч -8.0) дүр зурагтай байна (Зураг 2.6).

⁵ Economic Uncertainty Index

Зураг 2.5. Эдийн засгийн тодорхой бус байдал



Зураг 2.6. Эдийн засгийн тодорхой бус байдал, салбараар



Бусад үзүүлэлтүүд

Тайлант улиралд эрэлтийн болон экспортын хүлээлт өмнөх улирлаас 11.2 болон 3.6 нэгжээр тус тус буурч 100 орчим буюу өөрчлөлтгүй төлөвтэй ойролцоо утгатай гарлаа. Салбарын түвшинд авч үзвэл барилга, үйлчилгээ, дотоод худалдаа болон хэрэглэгчийн хүлээлт голлон буурсан бол аж үйлдвэрийн салбарын хүлээлт бага зэрэг нэмэгдсэн байна. Тодруулбал, эрэлтийн голлох салбарын хүлээлтүүд 91.0–102.8, экспортын голлох салбарын хүлээлтүүд 82.5–105.6 нэгжийн хооронд гарлаа.


Зээлийн хүү, төгрөгийн ханш болон нэгж бүтээгдэхүүний зардлын хүлээлт тайлант улиралд өсөж, индексийн утга 146-148 нэгжийн хооронд буюу нэмэгдэх хүлээлтэй гарлаа. Тус хүлээлтүүдийг салбарын түвшинд харвал үйлчилгээний салбарын ханшийн хүлээлт, дотоод худалдааны нэгж өртгийн хүлээлт буурсан бол бусад салбарын хүлээлтүүд өслөө. Мөн зээлийн хүүний хүлээлт бүх салбарт нэмэгдэж, тус үзүүлэлт нь 2022 оноос хойших хамгийн өндөр түвшин буюу 148 нэгжид хүрлээ.

Ажиллах хүчний зардлын хүлээлт өмнөх улираас бага зэрэг буурч 126 утгатай гарлаа. Салбарын түвшинд авч үзвэл хэрэглэгч болон барилгын салбарын хүлээлтүүд бага зэрэг нэмэгдсэн бол аж үйлдвэр, үйлчилгээ, дотоод худалдааны салбаруудад буурсан үзүүлэлттэй гарлаа.

Зураг 2.7. Эрэлтийн хүлээлтийн үзүүлэлт




Зураг 2.8. Экспортын хүлээлтийн үзүүлэлт




Зураг 2.9. Зээлийн хүүний хүлээлт



Зураг 2.10. Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн хүлээлт



Зураг 2.11. Нэгж бүтээгдэхүүний зардлын хүлээлтийн үзүүлэлт



Зураг 2.12. Ажиллах хүчний зардлын хүлээлтийн үзүүлэлт



III. Хавсралт 1. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн ерөнхий мэдээлэл

Түүвэр судалгааг 2025 оны 4 дүгээр сард явуулж, нийт 387 аж ахуйн нэгж (ААН) хамрагдсан бөгөөд өмчлөлийн хэлбэрээр авч үзвэл 361 (93%) нь хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК), 15 (4%) нь хувьцаат компани (ХК), үлдсэн 11 (3%) нь бусад төрлийн өмчлөлийн хэлбэртэй ААН-үүд байна /Хүснэгт 1.1/. Түүвэр судалгаанд хамрагдсан ААН-үүдийн тогтмол оролцоог авч үзвэл 116 (30%) нь сүүлийн дөрвөн улиралд хамрагдаж байсан, 145 (38%) нь өмнөх улиралд хамрагдсан, харин 126 (33%) нь шинээр оролцсон байна.

Хувийн хэвшлийн ААН-үүд судалгаанд голлон хамрагдсан бөгөөд тэдгээрийн 48% нь 20-с дээш, 16% нь 15-20 жилийн, 17% нь 10-15 жилийн, 16% нь 5-10 жилийн бол 3% нь 5-с доош жилийн турш үйл ажиллагаа эрхэлсэн ААН-үүд байна /Хүснэгт 1.2/.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл бөөний болон жижиглэн худалдааны 67 (17%), хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн 89 (23%), барилгын 80 (21%), хүнсний бус боловсруулах үйлдвэрлэлийн 31 (8%), үйлчилгээний 98 (25%) ААН-үүд судалгаанд хамрагдлаа /Хүснэгт 1.3/.

Жилийн борлуулалтын орлогоор авч үзвэл 2.5 тэрбум төгрөгөөс дээш орлоготой 182 (47%), 1.0 тэрбум төгрөгөөс 2.5 тэрбум төгрөгийн орлоготой 70 (18%), 300 саяас 1.0 тэрбум төгрөгийн орлоготой 72 (19%), 50.0-300.0 сая төгрөгийн орлоготой 44 (11%) аж ахуйн нэгжүүд судалгаанд оролцлоо /Хүснэгт 1.4/

Хүснэгт 1.1: Аж ахуйн нэгжийн тоо /өмчлөлөөр/

Өмчлөлийн хэлбэрийн ангилал	тоо	хувь
ХХК	361	93%
Хувьцаат компани	15	4%
Бусад	11	3%
НИЙТ ДҮН	387	100%

Хүснэгт 1.2: Аж ахуйн нэгжийн тоо /туришлага, жилээр/

Хугацааны ангилал	тоо	хувь
5 хүртэл	13	3%
5-10 хүртэл	60	16%
10-15 хүртэл	67	17%
15-20 хүртэл	61	16%
20-с дээш	186	48%
НИЙТ ДҮН	387	100%

Хүснэгт 1.3: Аж ахуйн нэгжийн тоо /салбараар/

Салбарын ангилал	тоо	хувь
Уул уурхай, олборлолт	9	2%
Боловсруулах үйлдвэрлэл (хүнсний)	89	23%
Боловсруулах үйлдвэрлэл (хүнсний бус)	31	8%
Барилга	80	21%
Бөөний болон жижиглэнгийн худалдаа	67	17%
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	10	3%
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	14	4%
Зочид буудал, байр, сууц болон хоол	11	3%
Мэдээлэл, холбоо	10	3%
Санхүүгийн болон даатгалын ү.а	17	4%
Үйлчилгээний болон бусад үйл ажиллагаа	21	5%
Боловсрол	6	2%
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамж	9	2%
Бусад	13	3%
НИЙТ ДҮН	387	100%

Хүснэгт 1.4: Аж ахуйн нэгжийн тоо /орлогоор/

Орлогын ангилал	тоо	хувь
50 сая төгрөг хүртэл	19	5%
50-300 сая төгрөг хүртэл	44	11%
300 сая-1.0 тэрбум төгрөг хүртэл	72	19%
1.0-2.5 тэрбум төгрөг хүртэл	70	18%
2.5 тэрбум төгрөгөөс дээш	182	47%
НИЙТ ДҮН	387	100%

Жилийн борлуулалтын орлого болон ажилчдын тооны бүлгээр ангилбал 10 хүртэл ажилтантай эсвэл 2.5 тэрбум төгрөг хүртэл орлоготой бичил ангилалд хамаарах 117 (30%), 10-аас 200 хүртэл ажилтантай эсвэл 2.5 тэрбум төгрөг хүртэл орлоготой жижиг, дунд ангилалд хамаарах 87 (23%), 200-с дээш ажилтантай эсвэл 2.5 тэрбум төгрөгөөс дээш орлоготой том ангилалд хамаарах 183 (47%) аж ахуйн нэгжүүд судалгаанд хамрагдлаа /Хүснэгт 1.5/.

Хүснэгт 1.5: Аж ахуйн нэгжийн тоо /орлого, ажилтны тооны бүлгээр/

Борлуулалтын орлого	Ажилчдын тоо /бүлгээр/				Бүгд
	< 10	11–49	50–199	200= <	
50 сая төгрөг хүртэл	18	1	0	0	5%
50-300 сая төгрөг хүртэл	36	8	0	0	11%
300 сая-1.0 тэрбум төгрөг хүртэл	45	26	1	0	19%
1.0-2.5 тэрбум төгрөг хүртэл	18	44	7	1	18%
2.5 тэрбум төгрөгөөс дээш	9	71	75	27	47%
НИЙТ ДҮН	126	150	83	28	100%

IV. Хавсралт 2. Аргачлалын тайлбар

Эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт (ESI)

Энэхүү үзүүлэлтийг тооцохдоо Евро комиссын “European Business Cycle Indicators” тайланд тусгагдсан аргачлалын дагуу тооцлоо. Эдийн засгийн мэдрэмжийн үзүүлэлт нь аж ахуйн нэгжийн болон хэрэглэгчдийн түүвэр судалгаанд хамрагдсан таван үндсэн салбарын аж ахуйн нэгж, хэрэглэгчдээс сонгогдсон асуултуудад өгсөн хариултуудын жигнэсэн дундаж үзүүлэлт юм. Аж үйлдвэр (жин 40%), үйлчилгээ (30%), хэрэглэгчид (20%), жижиглэн худалдаа буюу дотоод худалдаа (5%), барилгын салбарууд (5%) хамаарна. Аж үйлдвэрийн салбараас тухайн улирлын **шинэ захиалга**, **бэлэн бүтээгдэхүүний нөөц**, ирэх улирлын **үйлдвэрлэл**, барилгын салбараас тухайн улирлын **шинэ захиалга**, ирэх улирлын **ажил эрхлэлт**, дотоод худалдааны салбараас тухайн улирлын **борлуулалтын орлого**, **худалдан борлуулах барааны нөөц**, ирэх улирлын **борлуулалтын орлого**, үйлчилгээний салбараас тухайн улирлын **бизнесийн үйл ажиллагааны нөхцөл байдал**, **шинэ захиалга**, ирэх улирлын **борлуулалтын орлого**, хэрэглэгчдээс тухайн улирлын **санхүүгийн байдал**, ирэх улирлын **санхүүгийн байдал**, **хэрэглээ** болон **эдийн засгийн нөхцөл байдал** зэрэг үзүүлэлтүүдийг асууж, асуулт тус бүрийн эерэг сөрөг хариултуудын нийт хариултад эзлэх хувийн зөрүүгээр тодорхойлсон болно.